



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2022 оны 11 сарын 23-ны
өдрийн 6018 дугаарт бүртгэв.

2022 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/288

Улаанбаатар хот


Дүрэм батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар /Г.Батбаяр/, Газрын тосны бодлогын газар /Б.Анхбаяр/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Газрын тосны бодлогын газар /Б.Анхбаяр/, Ашигт малтмал, газрын тосны газар /Л.Баярмандал/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД  Ж.ГАНБААТАР

Бүртгэлийн дугаар 230
МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

2022 оны 11 сарын 16 ний одор

ГАЗРЫН ТОС, УЛАМЖЛАЛТ БУС ГАЗРЫН ТОСНЫ ЭРЭЛ, ХАЙГУУЛ, АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨХ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү дүрмийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд баримтлах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны суурь шаардлагыг тодорхойлоход оршино.

1.2 Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ажил олгогч нь ажиллагсдын эрүүл мэнд, амь насыг хамгаалах, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, техник тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангах, болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор, мөн тухайн орон нутгийн ард иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хүндэтгэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх үүрэгтэй.


1.3 Удирдлагын тогтолцоо нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, бодлого, шийдвэрт нийцсэн байх бөгөөд журмын хавсралтуудад заасан Монгол Улсын Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэмтэй холбоотой хууль, дүрэм, журам, стандартын жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

1.4 Энэхүү дүрмийг газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг өмчийн бүх хэлбэрийн байгууллага, аж ахуй нэгж, тэдгээрийн туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, ажил үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй ажил олгогч, ажилтан болон ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэн нь тухайн ажил олгогчийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, төлөвлөгөө, дүрэм, журам, зааварчилгааг дагаж мөрдөх үүрэгтэй.

2.2. Газрын тосны гэрээт талбайд хамаарах үйл ажиллагаа явуулж байгаа туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, борлуулагч, ажил үйлчилгээ үзүүлж буй иргэн, хуулийн этгээд нь тухайн ажил олгогчийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, төлөвлөгөө, дүрэм, журам, зааварчилгааг дагаж мөрдөх үүрэгтэй.



2.3. Ажил олгогч нь туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, борлуулагч, ажил үйлчилгээ үзүүлж буй иргэн, хуулийн этгээдээс үйл ажиллагааныхаа онцлог нийцсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, төлөвлөгөө, дүрэм, журам, зааварчилгаатай байхыг шаардаж болно.

2.3¹. Туслан гүйцэтгэгч ажил үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээдээс тухайн талбай дээр хийгдэх ажил үйлчилгээ бүрт эрсдэлийн үнэлгээг шаардах эрхтэй.

2.3^{1.1}. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан үйлдвэрлэлийн машин механизм, тоног төхөөрөмжид заасан шаардлага хангасан эсэхийг ажил олгогчоос шаардах эрхтэй.

2.3^{1.2}. Туслан гүйцэтгэгч, ажил үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээд нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж, шалгалт өгсөн байх.

2.4. Ажил олгогч нь өөрийн ажиллагсад болон туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, борлуулагч, ажил үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээд, иргэнд ажил олгогчийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, төлөвлөгөө, дүрэм, журам, зааварчилгааг сурталчилан таниулах, сургалт хийх, хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэгтэй.

2.5. Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан гэрээлэгч, оператор компани, туслан гүйцэтгэгч зэрэг газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй ажил олгогч нар нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасан ажлын байрандаа үйлдвэрлэлийн осол, осолд дөхсөн тохиолдол буюу аюултай тохиолдол, аюулаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах зорилгоор эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэж холбогдох бодлого төлөвлөгөө, дүрэм, журам, хөтөлбөр, заавар зэрэг баримт бичигт тусган хэрэгжүүлэн ажиллана.


2.6. Энэ журмын 2.5-д заасан аюул гэж (MNS ISO 45001:2018) стандартад заасан гэмтэл эсвэл эрүүл мэндийн хохиролд хүргэх нөлөөтэй хор хөнөөл, аюултай нөхцөл ба байдал үүсгэх боломжтой эх үүсвэрийг хамаарна.

2.7. Энэ журмын 2.5-досолд дөхсөн тохиолдол буюу аюултай тохиолдол гэж (MNS ISO 45001:2018) стандартад заасны дагуу ажлаас, эсвэл уг ажлыг гүйцэтгэж байх явцад гэмтэл эсвэл эрүүл мэндийн хохиролд хүргэж болох эсвэл хүргэсэн тохиолдол хамаарна.

Гурав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохион байгуулалт

3.1. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогч шууд хариуцна.

3.2. Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан, бүтэц, зөвлөлийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу ажиллуулна.



3.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульболон үйл ажиллагааны онцлогт хамаарах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн санхүүжилтыг шийдэж зориулалтын дагуу зарцуулах үүрэгтэй.

3.4.Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, төлөвлөгөө, холбогдох дүрэм, журам, стандарт, заавар зааварчилгааг боловсруулахдаа нийт ажиллагсдын оролцоог хангана.


3.5. Байгууллагын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдлыг нэвтрүүлж, ажлын байрны соёлд мөрдлөг болгон ажиллана.


3.6.Тухайн орон нутгийн ард иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хүндэтгэн үзэж оролцоог хангана.

3.7.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар гарсан алдаа, зөрчилд ажилтныг үл буруутгах зарчмыг баримтална.

Дөрөв. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо

4.1.Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, нэвтрүүлэх бөгөөд энэ нь Төлөвлөх – Хэрэгжүүлэх – Шалгах – Сайжруулах гэсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи бодлого, зорилтыг тодорхойлох, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, манлайлах, хяналт тавих, үнэлгээ хийх эргэх холбоо бүхий удирдлагын цогц үйл ажиллагаа байна (Зураг 1).





Зураг 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо

4.2. Ажил олгогч нь өөрийн үйл ажиллагааны цар хүрээ, хэрэгцээ шаардлагад нийцсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог боловсруулах эсхүл сонгон нэвтрүүлэх үүрэгтэй.

4.3. Газрын тосны салбарын ажил олгогчид, ажиллагсад өөрийн үйл ажиллагааны чиглэл тус бүрээр Монгол Улсын хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдөн ажиллах үүрэгтэй бөгөөд хэрэв байхгүй тохиолдолд Монгол Улсын хүлээн зөвшөөрсөн олон улсын стандарт, дүрэм, журамд үндэслэнэ. (Хавсралт).

4.4. Ажил олгогч нь хүснэгт 4.1.-т заасан шаардлагыг хангасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоотой байна.

Тав.Статистик мэдээлэлд тавигдах шаардлага

5.1.Газрын тосны үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд ажлын байрны аюулгүй байдлын талаар дараах статистик мэдээг холбогдох эрх бүхий

байгууллагад мэдээлнэ. Үүнд:


5.1.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор батлагдсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн холбогдох заалтын дагуу үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаар мэдээлнэ.

- i. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/234 тоот тушаалаар батлагдсан “Мэргэжлээс шалтгаалах өвчнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын дагуу мэргэжлээс шалтгаалсан өвчний талаар мэдээлнэ.
- ii. Осол гарсан тохиолдол бүрт Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын цахим бүртгэл мэдээллийн /om.inspection.mn/ санд бүртгүүлнэ.

5.2.Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага төрийн бусад байгууллага, компанийн хамт ноцтой ослын талаар магадлан шалгалт хийх үүрэгтэй. Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын эрх бүхий албан тушаалтныг саадгүй нэвтрүүлэх, эрх бүхий албан тушаалтны шаардсан хяналт шалгалтанд шаардлагатай бичиг баримтыг саадгүй гаргаж өгнө.

5.3. Хяналт шалгалт, мөрдөн шалгалтын үеэр байцаагчийн хүсэлт гаргаснаар Компани нь хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын байцаагчид аюулгүй байдлын төлөвлөгөө, аюулгүй байдлын бодлого, ажлын байран дахь аюул, эрсдэлийн үнэлгээ, стандартчилсан үйл ажиллагааны дадал, бусад баримт бичгийн хамт өгнө.


Зургаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны шаардлагууд



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны шаардлагууд	
Тогтолцооны шаардлага	Агуулга
	А. Ажил олгогчийн үүрэг
1. Ажил олгогчийн ХАБЭА-н бодлого, төлөвлөгөө	<p>a. Ажил олгогчийн ХАБЭА-н талаарх зорилго, зорилт, үүрэг</p> <p>b. Удирдлага, нэгжийн удирдах ажилтан, ажилтны үүрэг хариуцлага, оролцоог тодорхойлон нарийвчлан тусгах</p> <p>c. Үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах шаардлагатай хууль тогтоомж, бодлого, дүрэм, журам, стандарт, зааврыг тусгасан байна.</p> <p>d. Эрсдэлийн үнэлгээнд тавигдах шаардлагуудыг бодлого, дүрэм журамд тусгасан байна.</p> <p>e. Ажиллагсдын эрх (мэдэх, оролцох, татгалзах эрх гэх мэт).</p> <p>f. ХАБЭА-н бодлого, төлөвлөгөөг эрх бүхий албан тушаалтан баталгаажуулсан байна.</p> <p>Ажил олгогчийн батлагдсан ХАБЭА-н бодлого, төлөвлөгөөг нийт ажиллагсад болон туслан гүйцэтгэгч,</p>

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны шаардлагууд

Тогтолцооны шаардлага	Агуулга
	ханган нийлүүлэгч, ажил үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээд, иргэнд хүргүүлсэн байна.
2. ХАБЭА-н талаар хүлээх үүрэг, хариуцлага	<p>a. Ажил олгогч нь удирдлага, албан тушаалтан, ажиллагсадын ажлын байрны нөхцөл, онцлог, тавигдах шаардлагатай уялдуулан ХАБЭА-н талаар хүлээсэн үүрэг хариуцлагыг ХАБЭА-н бодлого, дүрэм журам, заавар, ажлын байрны тодорхойлолтод нарийвчлан тусгасан байна.</p> <p>b. Ажлын байран дахь аюулыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авч аюулгүй байдлыг хангана.</p>
3. Удирдлагын манлайлал, оролцоо	<p>a. Ажил олгогч буюу түүний удирдлага нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг шууд хариуцна.</p> <p>b. Удирдах албан тушаалтнууд нь ХАБЭА-тай холбоотой үйл ажиллагаанд манлайлан оролцох бөгөөд ажлын байр тус бүрт тавигдах ХАБЭА-н шаардлага, ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдлын дадал хэвшилд хяналт тавьж, ажиллагсадтай санал солилцож, шаардлагатай асуудлаар холбогдох шийдвэрийг гаргана.</p>
1. Аюулыг тодорхойлох, эрсдлийг үнэлэх	
2. Аюулыг тодорхойлох, эрсдлийг үнэлэх тогтолцоо	<p>a. Ажил олгогч нь ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах зорилгоор ажлын байр тус бүрээр эрсдэлийн үнэлгээг хийнэ. Ажлын байрны эрсдэлийн үнэлгээг эрх бүхий байгууллагаас батлан гаргасан "Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж"-ийн дагуу хийнэ.</p> <p>b. Аюулыг тодорхойлох, эрсдэлийн үнэлгээг хийх, хянахад оролцох шаардлагатай ажиллагсдыг сургалтад хамруулна.</p> <p>c. Дараах тохиолдолд аюулыг тодорхойлох, эрсдэлийн үнэлгээг шинээр болон шинэчлэн хийнэ:</p> <ul style="list-style-type: none"> • Осолд дөхсөн тохиолдол эсхүл осол гарсан тухай бүр • Шинэ технологи, үйл ажиллагаа нэвтрүүлсэн, шинээр тоног төхөөрөмж суурилуулсан, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд эрсдэл учруулахуйц бараа, материал ашиглах тохиолдолд, • Өмнө тодорхойлоогүй аюулыг хяналт,




 № 236
 XI/16
 M.Y.

1 6127151
 7700 680 9129294

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны шаардлагууд

Тогтолцооны шаардлага	Агуулга
	<p>шалгалтаар илрүүлсэн тохиолдолд,</p> <ul style="list-style-type: none"> • Тодорхой давтамжтайгаар арга хэмжээ авахаар заасан бол тухайн хугацаа болсон үед <p>d. Аюулыг тодорхойлон, эрсдэлийн үнэлгээ хийсэн үр дүнгийн талаар тайланг ажил олгогч нь удирдлагадаа гаргаж өгнө.</p> <p>e. Үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг эрсдэлтэй ажлын байрны сургалтанд 3 жил тутам хамруулна.</p> <p>f. Ажил олгогчийн удирдах албан тушаалтнууд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хувьд эрсдэлийн түвшин их гэж үнэлэгдсэн үйл ажиллагааны талаар мэдлэг, ойлголттой байх шаардлагатай ба манлайлан оролцоно.</p>
<p>2. Тухайн ажлын талбайд хамааралтай аюулыг тодорхойлох</p>	<p>a. Ажлын өдөр эхлэхээс өмнө тухайн ажлын талбайд хамааралтай аюулыг тодорхойлох талаар зохицуулалттай байна:</p> <ul style="list-style-type: none"> • түр эсхүл явуулын ажлын талбайд, • ажил олгогчийн өөрийн бус ажлын талбайд, • шинэ нөхцөл байдал, ажлын даалгавар, үйл явц, барилга болон тоног төхөөрөмж нэвтрүүлсэн үед, • аюулыг тодорхойлохдоо тухайн ажлын талбайн хувьд нөлөөлөлд өртөж болзошгүй ажиллагсдын оролцоог хангана.
<p>3. Аюулыг мэдээлэх</p>	<p>a. Ажилтан, нэгжийн удирдах ажилтан нь өдөр тутмын үйл ажиллагаанд учрах аюулыг мэдээлэх; аюултай нөхцөл байдал, аюултай ажлын дадлыг хэрхэн удирдах талаар зохицуулалттай байна.</p> <p>b. Аюулыг тодорхойлох талаар сургалтанд ажиллагсдыг хамруулна.</p>
<p>2. Аюулын хяналт</p>	
<p>1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд учирч болзошгүй аюулын хяналтын тогтолцоо</p>	<p>a. Ажил олгогч нь эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлсон ХАБЭА-д учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, арилгах, хяналт тавих тухай зохицуулалттай байна. Тавигдах шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх, • Аюулыг тодорхойлон эрсдэлийн түвшингээр эрэмбэлж, эрсдэлийн түвшин их аюулыг тэргүүн ээлжинд анхаарах, • Аюулд өртөж болзошгүй эрсдэлтэй ажлын байранд ажиллаж буй ажиллагсдын саналыг тусгах, • Үйл ажиллагаанд оролцогч талуудын үүрэг,



 №: 236
 2/16
 и.у


Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны шаардлагууд

Тогтолцооны шаардлага	Агуулга
	<p align="center">хариуцлагыг тодорхой заах,</p> <ul style="list-style-type: none"> • Хяналт-шинжилгээ, үнэлгээг тасралтгүй хийх, • Хяналт нь шатлалтай байна. <p>b. Аюулын хяналтын талаарх өөрчлөлтийг холбогдох ажиллагсдад мэдээлдэг байна.</p>
<p>2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд учирч болзошгүй аюулын хяналтууд</p>	<p>a. Ажил олгогч нь инженерийн болон захиргааны аюулын хяналтыг ажлын талбарт хэрэгжүүлнэ.</p> <p>b. Хууль тогтоомж болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд учирч болзошгүй аюулын хяналтын тогтолцооны дагуу шаардагдах хувийн хамгаалах хэрэгсэл (XXX)-ийг ажил олгогч нь хангана.</p> <p>c. XXX нь бүрэн бүтэн, ашиглалтын шаардлага хангасан байна.</p> <p>d. XXX-ийг зүй зохистой, зориулалтын дагуу ашиглах, засвар үйлчилгээ хийлгэх, хадгалах, хамгаалах талаар ажиллагсдад сургалт хийнэ.</p>
<p>3. Урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээ</p>	<p>a. Урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээ нь:</p> <ul style="list-style-type: none"> • Урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээ шаардлагатай эд хөрөнгийн бүртгэл гарган баримтжуулах асуудлыг тусгасан байна • Урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээний хуваарийг тусгана, • Хууль тогтоомжийн шаардлагуудыг хангасан байна, • Үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолтыг хангасан байна.
<p>4. Аюултай материал</p>	<p>a. Аюултай материалтай харьцах, ашиглах, хадгалах, үйлдвэрлэх, устгахтай холбоотой хууль тогтоомжид нийцсэн зохицуулалттай байна.</p> <p>b. Ажиллагсад аюултай материалын хэрэглээ, харьцаа, хадгалалт, устгахтай холбоотой сургалтад хамрагдсан байх.</p> <p>c. Аюултай материалуудад зохих шошго тайлбарыг заавал байршуулсан байх.</p> <p>d. Ажлын талбарт ашиглаж байгаа эсвэл хадгалж байгаа аюултай материалын үйлдвэрлэгчийн хор аюулын лавлах мэдээллийг(ХАЛМ) ажиллагсдад танилцуулсан байна.</p> <p>e. Ажиллагсдыг хими, биологийн ба цацраг идэвхт аюулд (аль холбогдох тохиолдолд) өртөх тохиолдолд ямар зохицуулалт, хяналт хэрэгжүүлэхийг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу төлөвлөсөн байна.</p>
<p>5. Ажлын байрны</p>	<p>a. Хууль, тогтоомжоор тогтоосон шаардлагыг хангасан</p>

1116127151
 VXA-00-9129294
 № 235
 ш/р
 х/16

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны шаардлагууд

Тогтолцооны шаардлага	Агуулга
дарамт, ялгаварлан гадуурхалт хүчирхийллээс сэргийлэх	<p>ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс сэргийлэх талаар зохицуулалттай байна.</p> <p>b. Ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс сэргийлэх бодлого, журмын талаар сургалтанд ажиллагсдыг тодорхой давтамжтай хамруулдаг байна.</p>
3. Ажлын байрны хяналт шалгалт	
1. Хяналт шалгалт	<p>a. Ажил олгогч нь ажлын байрны хяналт шалгалтын төлөвлөгөөтэй байна.</p> <p>b. Хяналт шалгалтын төлөвлөгөөнд дараах зүйлс хамаарна.</p> <ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагаа, • Ажлын талбарууд, • Тоног төхөөрөмж, ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгсэл • Бараа, материал, • Тухайн ажлын байран дахь аюул. <p>c. Хяналт, шалгалтын төлөвлөгөөнд шалгалтын төрөл, давтамж, шаардлагыг тодорхойлсон байна.</p> <p>d. Хяналт шалгалтыг хийхэд дараах албан тушаалтнуудыг хамруулж болно.</p> <ul style="list-style-type: none"> • Удирдах дээд шатны албан тушаалтан, • Дунд шатны менежер, • Нэгжийн удирдах ажилтан, • Ажиллагсад. <p>e. Ажил олгогч нь хяналт шалгалтын ажилтнуудад дараахь зүйлд үнэлгээ хийх заавар, маягт, шалгах хуудас өгнө. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагаа, • Ажлын талбарууд, • Тоног төхөөрөмж, • Бараа, материал, • Тухайн ажлын байран дахь аюул. <p>f. Хяналт шалгалтын дүнд илрүүлсэн зөрчил, дутагдлыг тухай бүр засаж, залруулах зохицуулалт.</p> <p>g. Ажил олгогчийн ажлын байрны хяналт шалгалт явуулахад оролцох ажиллагсдын сургалт.</p>
4. Дадлагажуулалт, зааварчилгаа, сургалт	
1. ХАБЭА-н тухай зааварчилгаа	<p>a. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Сургалт зохион байгуулалт. Үндсэн дүрэм” MNS 4969:2000 Монгол Улсын стандарттай уялдуулан зааварчилгааг өгнө.</p> <p>b. Шинэ болон шилжин ирсэн ажиллагсдад дэлгэрэнгүй</p>



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны шаардлагууд

Тогтолцооны шаардлага	Агуулга
	<p>зааварчилгаа өгнө. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, дүрэм журам, • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үүрэг хариуцлага, • Ажиллагсдын эрх (татгалзах эрх, мэдэх эрх, оролцох эрх), • Тухайн ажлын байртай холбоотой аюул, түүний хяналт, • Аюултай материалтай харьцах, хадгалах, устгахтай холбоотой зохицуулалт • Холбогдох хууль тогтоомжийн шаардлагууд, • Сахилгын болон дагаж мөрдүүлэх бодлого. Онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний зохицуулалт (үүнд дохиоллын системийг оруулна), • Ажлын байран дээрх аюулыг мэдээлэх, тайлагнах, • Осол, осолд дөхсөн тохиолдлыг мэдээлэх, тайлагнах. • Тухайн зааварчилгааг өгч байгаа хүн ба ажилтны гарын үсэг зурж баталгаажуулсан баримт. <p>с. Ажилтан шинэ ажлын байран дээр ажиллаж эхлэхэд тухайн ажлын байртай холбоотой тодорхой зааварчилгаа өгөх зохицуулалт.</p>
<p>2. Тухайн ажилд хамаарах сургалт</p>	<p>a. Шаардлагатай тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хувьд эрсдэлийн түвшин их албан тушаал/мэргэшилд хамаатай тавигдах шаардлага</p> <p>b. Ажилтан ажил хийж эхлэхээс өмнө тавигдах шаардлагыг хангасан эсэхийг шалгах зохицуулалт</p> <p>c. Шаардлагатай бол тухайн ажилд хамаарах сургалт, гэрчилгээ олгох.</p> <p>d. Шинэ ба шилжүүлэн томилсон ажиллагсдын чадамжид үнэлгээ хийх зохицуулалт.</p>
<p align="center">5. Гамшгийн үед Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалаар баталсан "Мэргэжлийн ангийн дүрэм" -ийн дагуу арга хэмжээ авах</p>	
<p>1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө</p>	<p>a. Ажил олгогчийн үйл ажиллагаа, хууль тогтоомж шаардлагад нийцсэн, онцгой байдлын болзошгүй нөхцөл байдлын хувилбаруудыг хангалттай хэмжээнд тодорхойлж, тухай бүрт авч хэрэгжүүлэх гамшгийн хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй байх</p> <p>b. Байгууллага, аж ахуй нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Монгол Улсын Шадар Сайдын 2018 оны</p>

№ 230
 xi/16
 и.ч

1110127151
 УХА-80 9129294

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны шаардлагууд

Тогтолцооны шаардлага	Агуулга
	<p>120 дугаар тушаалын 3 дугаар хавсралт “ Байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ын дагуу боловсруулан хэрэгжүүлнэ.</p> <p>c. Эмнэлгийн тусламж шаардлагагүй гамшгийн үед зориулсан тоног төхөөрөмж, хангамж хэрэгслийг тодорхойлж, шаардлагын дагуу бэлэн байдлыг хангасан байх.</p> <p>d. Гамшгийн үеэр үүрэг хүлээх ажилтнууд ажил олгогчийн үйл ажиллагаанд хамааралтай онцгой байдлын хувилбаруудыг тодорхойлох үйл явц, тогтолцооны талаар мэддэг байх.</p>
<p>2. Эмнэлгийн тусламж шаардагдах онцгой байдал</p>	<p>a. Дараахь нөхцөл байдлын зохицуулалт:</p> <ul style="list-style-type: none"> • Эмнэлгийн тусламж шаардлагатай онцгой байдал, • Анхны тусламж үзүүлэх • Анхны тусламж үзүүлсэн тохиолдлыг мэдээлэх, тайлагнах. <p>b. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн дагуу хангалттай тооны ажиллагсдыг анхны тусламж үзүүлэх сургалтанд хамруулсан байна.</p> <p>c. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн дагуу зохих анхны тусламжийн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангасан байна.</p>
<p>3. Үүрэг хариуцлага ба сургалт</p>	<p>a. Ажиллагсадын үүрэг хариуцлагыг тодорхойлсон онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөө.</p> <p>b. Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан үүрэг хариуцлагыг холбогдох ажиллагсад танилцуулах.</p> <p>c. Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөөний дагуу тодорхой үүрэг хариуцлага хүлээсэн ажиллагсад сургалт явуулах.</p>
<p>4. Ажлын байрны нүүлгэн шилжүүлэлт, дадлага сургууль</p>	<p>a. Онцгой байдлын үеэр хариу арга хэмжээ авах төлөвлөгөөний үр дүнтэй байдалд үнэлгээ хийх зохицуулалттай байх, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Жилд нэгээс доошгүй удаа шалгах, • Доголдлыг илрүүлэх арга • Доголдлыг арилгах арга.
<p>6. Ослыг мэдээлэх, тайлагнах, магадлан шалгалт хийх</p>	<p>6. Ослыг мэдээлэх, тайлагнах, магадлан шалгалт хийх</p>
<p>1. Ослыг мэдээлэх, тайлагнах</p>	<p>a. Ослын дотоод тайлагналын зохицуулалтанд дараахь зүйлсийг тусгах:</p> <ul style="list-style-type: none"> • Ажлын байран дээрх ослыг даруй мэдээлэх, тайлагнах шаардлагатай байх. Үүнд гэмтэл,


11/230

 11/16

 УХ-150 9129284

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны шаардлагууд

Тогтолцооны шаардлага	Агуулга
	<p>өвчлөл, осолд дөхсөн тохиолдол, ажиллахаас татгалзсан тохиолдлыг оруулна,</p> <ul style="list-style-type: none"> • Хууль тогтоомжийн дагуу шаардагдах нотлох баримтыг бүрдүүлэх, хамгаалах • Төрийн холбогдох эрх бүхий байгууллагуудад ослыг мэдээлэх, тайлагнах зохицуулалтыг тусгах <p>b. Ажиллагсад ослыг мэдээлэх, тайлагнах үйл явц зохицуулалтын талаар ойлголттой байх.</p>
<p>2. Ослыг магадлан шалгах</p>	<p>a. Ажил олгогч нь ослын магадлан шалгахдаа дараах шаардлагыг хангаж ажиллана:</p> <ul style="list-style-type: none"> • Ослыг магадлан шалгах зорилго зорилтыг тодорхойлох, • Магадлан шалгах үйл ажиллагаанд оролцогчдын үүрэг, хариуцлагыг тодорхой тусгах • Тухайн ажилд мэргэшсэн ажилтныг оролцуулах • Магадлан шалгах шаардлагатай ослын төрлүүдийг тодорхойлох, үүнд ажлаас татгалзсан тохиолдлыг оруулах • Осолд нөлөөлсөн хүчин зүйлсийг тодорхойлох, • Магадлан шалгалтын үр дүнд түүний дотор нөлөөлсөн хүчин зүйлсийг багтаан дүн шинжилгээ хийх, • Удирдах албан тушаалтан магадлан шалгалтын бичиг баримтыг хянан, баталгаажуулах. <p>b. Ажил олгогчийн бүх шатны удирдах ажилтанууд магадлан шалгалтыг эхлүүлэх, зохицуулах, хянахад эсхүл магадлан шалгалтын зохицуулалтын дагуу ямар үүрэг хариуцлага хүлээж буй талаар мэдлэг ойлголттой байх.</p> <p>c. Магадлан шалгах үүрэг хүлээсэн ажилтныг холбогдох шалгалтын сургалтанд хамруулсан байх.</p> <p>d. Магадлан шалгагчийн зөвлөмжийг баримтжуулж, хэрэгжүүлэх үйл явц.</p> <p>e. Магадлан шалгалтын үр дүн болон авах арга хэмжээний талаар ажиллагсад болон гэрээлэгч нарт мэдээлэх үйл явц.</p>
<p>3. Статистикийн дүн шинжилгээ</p>	<p>a. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд холбоотой статистикийг жил бүр бүртгэх,</p> <p>b. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд холбоотой статистикт дүн шинжилгээ хийж чиг хандлагыг тодорхойлох.</p>
<p>7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлдэх</p>	
<p>1. Хөдөлмөрийн аюулгүй</p>	<p>a. Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар хоёр талт харилцаа холбоо явуулах:</p>



 № 230
 xi/16
 ш.у


1116127151
 УХА0580 9129294

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны шаардлагууд

Тогтолцооны шаардлага	Агуулга
байдлын харилцаа холбоо	Үүнд: <ul style="list-style-type: none"> • Тодорхой давтамжтай тогтмол явуулна, • Бүх шатны ажиллагсдыг хамруулна. б. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг хоёр талт харилцаа холбоогоор тодорхойлж цаг тухайд нь залруулна.
2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны баримт, бүртгэл	а. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой баримтыг дор хаяж 5 жил хадгална, үүнд: <ul style="list-style-type: none"> • Сургалтын баримт, • Хяналт шалгалтын баримт, • Анхны тусламжийн баримт, • Осол, тохиолдлын мэдээлэл, тайлан, ослын магадлан шалгалт • Аюулгүй байдлын хурлын тэмдэглэл орно.
3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны үнэлгээ	а. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой дотоодын аудит хийх зохицуулалт б. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог, энэхүү тогтоцооны аудитын үр дүн эсхүл жилийн статистик судалгааны дүнд тулгуурлан тасралтгүй сайжруулах зохицуулалтыг хийх. с. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцах удирдах албан тушаалтныг томилох. д. Удирдах албан тушаалтан өмнөх жилийн үр дүнд тулгуурлан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог сайжруулах, стратегийн чиглэл өгдөг байх
Б. Бусад холбогдох талууд	
1. Туслан гүйцэтгэгчид, зочид ба бусад	а. Туслан гүйцэтгэгчид, ханган нийлүүлэгч, ажил үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээд, иргэдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай бодлогыг хүргүүлж, танилцуулга хийх. б. Дараахь хүмүүст зориулсан ажлын талбайд хамаарах зааварчилгаа өгч, үүргийг танилцуулах: <ul style="list-style-type: none"> • Туслан гүйцэтгэгчид • Ханган нийлүүлэгч • Ажил үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээд, иргэд • Зочид с. Ажил олгогчийн удирдлага дор биш боловч нөлөөлөлд өртөх бусад талуудын аюулгүй байдлыг хамгаалах зохицуулалттай байх. д. Туслан гүйцэтгэгчид, ханган нийлүүлэгч, ажил үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээд, иргэдийг сонгон шалгаруулах, хяналт, үшинжилгээ, үнэлгээ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны шаардлагууд

Тогтолцооны шаардлага	Агуулга
	<p>хийх шалгуур үзүүлэлттэй байх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шалгуур үзүүлэлт, • Туслан гүйцэтгэгчийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар хүлээх үүргийг гэрээнд тодорхой тусгасан байх, • Ажил олгогч нь гэрээний хүчинтэй хугацаанд туслан гүйцэтгэгчид, ханган нийлүүлэгч, ажил үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээд, иргэдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийх, доголдол илэрвэл арилгуулах тухай тусгах, • Гэрээний заалтыг зөрчсөн тохиолдол болон цаашид гэрээг сайжруулахтай холбоотой үнэлгээ хийх талаар тусгах. <p>e. Ажил олгогч нь ажлын талбай дээр үйл ажиллагаа эрхэлж эсвэл бүтээгдэхүүн хүлээн авч байгаа байгаа туслан гүйцэтгэгчид, ханган нийлүүлэгч, ажил үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээдиргэдэд аюулыг тодорхойлох болон хянах талаарх зохицуулалтыг танилцуулах,</p> <p>f. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын дадалд нь нөлөөлөх үйл ажиллагааны өөрчлөлт гарсан тохиолдолд туслан гүйцэтгэгчид, ханган нийлүүлэгч, ажил үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээд, иргэдэд мэдэгдэх зохицуулалттай байх</p>
В.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл ба гишүүд	
<p>1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн</p>	<p>a. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлагыг тодорхойлсон байх</p> <p>b. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах удирдамж, холбогдох хууль тогтоомжийн шаардлагууд тодорхойлсон байх</p> <p>c. Ажил олгогч нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүдийг хуулийн дагуу сонгох.</p> <p>d. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүдийн нэр, холбоо барих дугаарыг нийт ажиллагсдад мэдээлэх.</p> <p>e. Зөвлөл нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбоотой санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авах, хянах, шийдвэрлэх зохицуулалттай байх</p>
<p>2. Хөдөлмөрийн аюулгүй</p>	<p>a. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүдийн хууль тогтоомжийн дагуу</p>



 № 236
 2016
 м.у.р


1116127151
 УХА0580 9129294

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны шаардлагууд

Тогтолцооны шаардлага	Агуулга
байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагаа	<p>хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлох.</p> <p>b. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүдэд зориулсан сургалттай байх.</p> <p>c. Ажиллагсад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой санал хүсэлт, өргөдөл гомдол гаргах зохицуулалттай байх.</p> <p>d. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн хурлын хөтөлбөр, тэмдэглэл хөтөлдөг байх.</p> <p>e. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн хурлын шийдвэрийг нийт ажиллагсдад мэдээлдэг байх.</p> <p>f. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт, мөн зөвлөл нь өргөдөл гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэсэн эсэхийг хянах зохицуулалттай байх,</p>
3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн эрх хэмжээ	<p>a. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүд дараах эрх хэмжээтэй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Ажлын байранд дээр хяналт шалгалт хийх, • Ослын тайланг хянах • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн жил бүрийн статистикт өөрийн мэдээллийг гаргаж өгөх, статистик мэдээлэлд хяналт тавих, • Бусад <p>b. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлөөс удирдах болон бусад албан тушаалтанд зөвлөмж өгөх</p>


Долоо. Бусад

7.1 Дээрх дүрмийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Зөрчлийн тухай хуульд болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.



Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн дүгээр хавсралт


Монгол Улсын Газрын тосны салбарт мөрдөн ажиллах хууль дүрэм журам, стандартууд



№	Мэргэжил, үйл ажиллагааны чиглэл	Энэ чиглэлээр Монгол улсад мөрдөгддөг хууль, тавигддаг шаардлагууд, стандарт, дүрэм журам
1	Газрын тосны геологи-геофизикийн судалгаа, эрэл-хайгуулын аюулгүй ажиллагаа	<ol style="list-style-type: none"> 1. Газрын тосны хууль (шинэчилсэн найруулга). УБ, 2014 он 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, УБ, 2008 он 3. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавих тухай (Ерөнхийлөгчийн шийдвэр) 1995-2-22, №39 4. Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам. УУС-ын тушаал, 2014-9-12, №202 5. Геологи-хайгуулын ажилд мөрдөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм. УБ, ГУУУЯ, 1985 он 6. MNS-6200: 2010 Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн гарын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага. УБ, 2010 он 7. Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн аюулгүй байдлын дүрэм (ОХУ) 8. СҮТ 6276—2014. БНХАУ-ын газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн стандарт (Газрын тос, байгалийн хийн салбарын эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны удирдлагын тогтолцоо)- <ol style="list-style-type: none"> 8.1. СҮТ 6609-2004 “Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо 8.2. СҮТ 6280-2013 “Газрын тосны геофизикийн багийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны менежментийн дүрэм 8.3. СҮТ 6283-1997 “Эрүүл мэнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа” 8.4. СҮТ 6362-1998 “Газрын тос, хийн цооногийн ашиглалтын аюулгүй байдал, хүрээлэн буй орчны удирдлагын тогтолцоо 8.5. СҮТ 6048-2007 “хүндийн хүчний, соронзон, цахилгаан хүчний аюулгүй байдал байгаль орчны менежментийн журам”


Handwritten notes and stamps in red ink at the bottom of the table, including a signature and the number 116.

2	Газрын тосны өрөмдлөгийн аюулгүй ажиллагаа	<ol style="list-style-type: none"> 1. Газрын тосны хууль (шинэчилсэн найруулга). УБ, 2014 он 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль.УБ, 2008 он 3. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавих тухай (Ерөнхийлөгчийн шийдвэр).1995-2-22, №39 4. Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам.УУС-ын тушаал. 2014-9-12, №202 5. MNS-6200: 2010 Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн гарын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага.УБ, 2010 он 6. Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн аюулгүй байдлын дүрэм (ОХУ)- "Өрөмдлөгийн үйл ажиллагааны үйлдвэрлэлийн нарийвчилсан зураг төслийг боловсруулахад тавигдах шаардлага
3	Газрын тосны олборлолтын аюулгүй ажиллагаа	<ol style="list-style-type: none"> 1. Газрын тосны хууль (шинэчилсэн найруулга). 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, УБ, 2008 он 3. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавих тухай (Ерөнхийлөгчийн шийдвэр),1995-2-22, №39 4. Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам, УУС-ын тушаал, 2014-9-12, №202 5. MNS-6200: 2010 Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн гарын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага ,УБ, 2010 он 6. Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн аюулгүй байдлын дүрэм (ОХУ)- "Олборлолтын үйл ажиллагааны үйлдвэрлэлийн нарийвчилсан зураг төслийг боловсруулахад тавигдах шаардлага"
4	Газрын тосны байгууламжийн угсралт, суурилуулалт, ашиглалтын аюулгүй ажиллагаа	<ol style="list-style-type: none"> 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, УБ, 2008 он 2. Даралтат савны төхөөрөмжлөл, аюулгүй ашиглах дүрэм,УБ, 2008 он
5	Газрын тосны ашиглалтын аюулгүй ажиллагаа	<ol style="list-style-type: none"> 1. Газрын тосны хууль (шинэчилсэн найруулга). УБ, 2014 он 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, УБ, 2008 он 3. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавих тухай (Ерөнхийлөгчийн шийдвэр) 1995-2-22, №39 4. Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам, УУС-ын тушаал, 2014-9-12, №202 5. MNS-6200: 2010 Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас




 1116127151
 УХА0580 9129294

		<p>эвдэрсэн гарын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага, УБ, 2010 он</p> <p>6. Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн аюулгүй байдлын дүрэм (ОХУ)</p> <p>7. SY/T 6276-2014 стандарт(БНХАУ)-дүйцүүлэн хэрэглэх зөвшөөрөлтэй</p> <p>6.1.AQ 2037-2012 Газрын тосны үйлдвэрлэлийн аюулгүй байдлын стандартчиллын удирдамж</p> <p>6.2.AQ 9006-201 Аж ахуйн нэгжийн аюулгүй байдлын үйлдвэрлэлийн стандартчиллын үндсэн хэм хэмжээ</p> <p>8. Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн аюулгүй байдлын дүрэм (ОХУ)-"Олборлолтын үйл ажиллагааны үйлдвэрлэлийн нарийвчилсан зураг төслийг боловсруулахад тавигдах шаардлага"</p>
6	Газрын тосны хадгалалтын аюулгүй ажиллагаа	<p>1. Монгол улсын Замын хөдөлгөөний тухай хууль</p> <p>2. Газрын тосны хууль (шинэчилсэн найруулга). УБ, 2014 он</p> <p>3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, УБ, 2008 он</p> <p>4. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавих тухай (Ерөнхийлөгчийн шийдвэр)1995-2-22, №39</p> <p>5. Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам, УУС-ын тушаал, 2014-9-12, №202</p>
7	Газрын тос тээвэрлэлт, дамжуулалтын аюулгүй ажиллагаа	<p>1. Монгол улсын Замын хөдөлгөөний тухай хууль</p> <p>2. Газрын тосны хууль (шинэчилсэн найруулга). УБ, 2014 он</p> <p>3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, УБ, 2008 он</p> <p>4. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавих тухай (Ерөнхийлөгчийн шийдвэр)1995-2-22, №39</p> <p>5. Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам, УУС-ын тушаал, 2014-9-12, №202</p>
8	Газрын тосны байгууламжийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа	<p>1. Газрын тосны хууль (шинэчилсэн найруулга). УБ, 2014 он</p> <p>2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, УБ, 2008 он</p>



Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн 2-дугаар хавсралт



Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанд ашиглах боломжтой олон улсын болон Монгол Улсын стандарт, шаардлагууд

1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, нэр томъёо тодорхойлолт MNS4967:2000;
2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага MNS4968:2000;
3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа MNS 4969:2000A. Үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо;
4. Energy Safety Canada (Канадын эрчим хүчний аюулгүй байдал), аюулгүй байдлын төлөвлөлт, дадал, аюулгүй байдлыг баталгаажуулах гэрчилгээ (ISO45001:2018 – тай дүйцэхүйц гэрчилгээ);
5. ISO45001:2018, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо, хэрэгжүүлэх заавар;
6. International Association of Oil and Gas Producers (Газрын тос, байгалийн хий олборлогчдын олон улсын холбоо), Газрын тос, байгалийн хийн салбарт эрсдлийг удирдаж, өндөр түвшний гүйцэтгэлийг хангахад чиглэсэн Газрын тос, Байгалийн Хий олборлогчдын Олон Улсын холбоо болон IPIECA-ын хамтарсан үйл ажиллагааны удирдлагын тогтолцооны хүрээ;
7. Газрын тосны салбарын стандарт үйл ажиллагааны дадал Energy Safety Canada (Канадын эрчим хүчний аюулгүй байдал), стандарт, үйл ажиллагааны дадал;
8. American Petroleum Institute (Америкийн Газрын тосны институт), хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартууд;
9. IPIECA, аюулгүй байдлын талаар өргөн хүрээний лавлах материал, тайлан;
10. Energy Safety Canada (Канадын эрчим хүчний аюулгүй байдал), Аюулын үнэлгээний талаар лавлах материал, маягтууд;
11. Health and Safety Executive, UK (Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гүйцэтгэх удирдлага, Их Британи), эрсдэлийг удирдах, эрсдэлийн үнэлгээг хийх үйл явц.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

